

**БИЕТ БУС СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ
ТУХАЙ КОНВЕНЦ**

**CONVENTION FOR THE SAFEGUARDING OF THE
INTANGIBLE CULTURAL HERITAGE**

Paris, 17 October 2003

2004

Улаанбаатар, Монгол улс

**Биет Бус Соёлын Өвийг Хамгаалах
тухай Конвенц**

НҮБ-ын Боловсрол, Шинжлэх Ухаан, Соёлын байгууллагын /цаашид ЮНЕСКО гэх/ Ерөнхий Бага Хурал 2003 оны XI сарын 27-оос X сарын 17-ны өдрүүдэд хуралдсан ээлжит 32-р дугаар чуулганаараа:

- Хүний эрхийн тухай 1948 оны Түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай 1966 оны олон улсын Пакт, Иргэний болон улс төрийн эрхийн тухай 1966 оны олон улсын Пакт зэрэг одоо мөрдөгдөж байгаа хүний эрхийн тухай олон улсын эрх зүйн актуудыг иш үндэс болгон;
- Уламжлалт соёл ба ардын урлагийг хадгалж, хамгаалах тухай ЮНЕСКО-гийн 1989 оны Зөвлөмж, Соёлын олон төрөл зүйлийн тухай 2001 оны Түгээмэл тунхаглал, соёлын сайд нарын дугуй ширээний 3-р уулзалтаар баталсан Стамбулын 2002 оны Тунхаглалд онцлон тэмдэглэсэнчлэн соёлын олон төрөл зүйлийн эх ундрага, тогтвортой хөгжлийн баталгаа болсон соёлын биет бус өвийн чухал ач холбогдлыг үнэлж;
- Биет ба биет бус соёлын өв болон байгалийн өвийн нягт харилцан хамаарлыг харгалзан үзэж;
- Даяаршил ба нийгмийн шинэчлэлт өөрчлөлтийн үйл явц нь хүмүүсийн хамтын нийгэмлэгүүдийн дунд шинээр харилцан ярилцаж ойлголцох өөрчлөх сайхан нөхцөл боломжийг бий болгож байгаа хэдий ч үл тэвчих үзлийн тарьж буй хөнөөлийн нэгэн адил ялангуяа биет бус соёлын өвийг хамгаалах хөрөнгө мөнгө дутагдсанаас энэхүү өв устаж мөхөх, эвдэрч сүйрэх ноцтой аюул занал үүсгэж байгааг хүлээн зөвшөөрч;
- Хүн төрөлхтний биет бус соёлын өвийг хамгаалахын төлөө дэлхий дахинаараа хүсэн эрмэлзэж, бүх нийтээр сэтгэл зовниж буйг ухааран;
- Хүмүүсийн тодорхой хамтын нийгэмлэгүүд ялангуяа нутгийн хүмүүсийн хамтын нийгэмлэг, бүлгүүд, зарим тохиолдолд хувь хүмүүс биет бус соёлын өвийг бүтээх, хадгалж хамгаалах, сэргээн бүтээх үйлсэд чухал үүрэг гүйцэтгэж, соёлын олон төрөл зүйлийг улам баяжуулан, хүний бүтээл туурвилыг тэтгэн дэмжиж байдгийг хүлээн зөвшөөрч;

Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай 1972 оны Конвенц зэрэг соёлын өвийг хамгаалахад чиглэгдсэн эрх зүйн хэм хэмжээ тогтоох механизмыг бүрдүүлэхэд ЮНЕСКО-гийн үйл ажиллагаа асар их нөлөөтэй болохыг онцлон тэмдэглээд;

- Өнөөдөр биет бус соёлын өвийг хамгаалах талаар хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа алив нэг эрх зүйн олон талын баримт бичиг байхгүй байгааг дахин нотлоод;
- Соёлын болон байгалийн өвийн талаар мөрдөгдөж байгаа олон улсын Гэрээ, Зөвлөмж, шийдвэрүүдийг биет бус соёлын өвд холбогдолтой шинэ шинэ заалтуудаар нэмж баяжуулах шаардлагатай гэж үзээд;
- Биет бус соёлын өв болон түүнийг хамгаалахын чухлыг ялангуяа залуу үеийнхэнд гүнзгий ойлгуулан ухамсарлуулахын зайлшгүй чухлыг харгалзан;
- Хамтран ажиллаж, харилцан туслалцах замаар олон улсын хамтын нийгэмлэг нь энэхүү Конвенцид оролцогч улс орнуудтай хамтран биет бус соёлын өвийг хамгаалах үйл хэрэгт дэмжлэг үзүүлэх ёстой гэж үзэж;
- Биет бус соёлын өвд холбогдолтой ЮНЕСКО-гийн Хөтөлбөрүүд, тухайлбал, Хүн төрөлхтөний аман ба биет бус соёлын өвийн шилдэг дээжист тунхаглах хөтөлбөрийн тухай дахин сануулж ;
- Хүмүүс хоорондоо ойртон нягтрах, тэдний дунд харилцан солилцоо, харилцан ойлголцол батжин бэхжихэд ач холбогдол бүхий хүчин зүйл болох биет бус соёлын өвийн үнэлж баршгүй үүргийг анхааран үзэж;

2003 оны 10 дугаар сарын 17-ны өдөр энэхүү Конвенцийг батлав.

I. Ерөнхий зүйл

1-р зүйл. Конвенцийн зорилго

Энэхүү Конвенцийн зорилго нь:

- А. Биет бус соёлын өвийг хамгаалах;
- Б. Тухайн хүмүүсийн хамтын нийгэмлэгүүд, бүлгүүд, хувь хүмүүсийн биет бус соёлын өвийг хүндэтгэх явдлыг баталгаажуулах;
- В. Биет бус соёлын өв, түүнийг харилцан талархан үнэлж, хөгжүүлэхийн чухлыг орон нутагт улмаар үндэсний болон олон улсын хэмжээнд ухамсарлан ойлгох явдлыг дээшлүүлэх;
- Г. Олон улсын хамтын ажиллагаа болон тусламжийг хангах;

2-р зүйл. Тодорхойлолт

Энэхүү Конвенцийн зорилгод нийцүүлэн:

1. Биет бус соёлын өв гэдэг нь хүмүүсийн хамтын нийгэмлэг, бүлэг хүмүүс, зарим тохиолдолд хувь хүн соёлын өвийнхөө нэг бүрэлдхүүн хэсэг гэж хүлээн зөвшөөрсөн зан заншил, дүрслэх ба илэрхийлэх хэлбэрүүд, мэдлэг болон дадал чадвар, түүнчлэн эдгээртэй холбоо бүхий багаж зэмсэг, эд зүйлс, урлагийн бүтээлүүд, мөн соёлын тухайн төрөлд үйлчлэх орон зай юм. Үеэс үед дамжин уламжлагдах биет бус соёлын өв нь хүмүүсийн хамтын нийгэмлэг, бүлгүүдээр дамжин хүрээлэн буй орчин, байгаль, түүхийн харилцан үйлчлэлийн явцад байнга сэргээгдэн шинэчлэгдэж, басхүү өвөрмөц байдал, залгамж чанараа хадгалан үлдэх, соёлын олон төрөл зүйл, хүний бүтээлч туурвилыг хүндэтгэх сэтгэл мэдрэмжийг хүмүүст төрүүлж хөгжүүлэхэд нөлөөлж байдаг юм. Энэхүү Конвенцийн чухамхүү зорилго бол хүний эрхийн талаар мөрдөгдөж байгаа олон улсын эрх зүйн актууд, түүнчлэн хүмүүсийн хамтын нийгэмлэг, бүлэг, хувь хүмүүсийн харилцан хүндэтгэл болон тогтвортой хөгжлийн шаардлагуудад нийцсэн л биет бус соёлын зөвхөн тийм өвийг авч үзэх болно.
2. “Биет бус соёлын өв” нь энэ зүйлийн нэгдүгээр хэсэгт тодорхойлсон ёсоор дараах хэлбэрүүдээр илэрнэ.
 - А. Биет бус тухайн соёлын өвийг тээгч эх хэлийг оруулаад аман уламжлал, түүнийг илэрхийлэх хэлбэрүүд;
 - Б. Урлагийн тоглож үзүүлэх хэлбэрүүд;
 - В. Зан заншил, зан үйл, баяр ёслолууд;
 - Г. Байгаль ба дэлхий орчлон ертөнцийн тухай мэдлэг, зан заншлууд;
 - Д. Уламжлалт гар урлал;
3. “Хамгаалалт” гэдэг нь биет бус соёлын өвийг албан ба албан бус боловсролын шугамаар таньж тогтоох, баримтжуулах, шинжлэн судлах, хадгалж хамгаалах, сурталчлан түгээх, үүрэг ач холбогдлыг нь дээшлүүлэх, түүнийг өвлөн уламжлах явдлыг баталгаажуулах, улмаар энэ өвийн төрөл хэлбэрийг сэргээх зэргээр амьдрах чадварыг нь хангахад чиглэгдсэн арга хэмжээнүүд юм.
4. “Оролцогч улсууд” гэдэг нь энэхүү Конвенциор нэгдсэн бөгөөд уг Конвенц хүчин төгөлдөр болж мөрдөгдөж байгаа улс орнуудыг хэлнэ.
5. Энэхүү Конвенц нь 33-р зүйлийн нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрч, түүний оролцогч нь болсон бөгөөд дээрх зүйлд нэр заасан нутаг дэвсгэрүүдэд хүчин төгөлдөр хэрэгжинэ. Энэ утгаар “Оролцогч улсууд” гэдэг нь дээрхи нутаг дэвсгэрт мөн хамаарна.

3-р зүйл. Олон Улсын эрхзүйн бусад актуудтай холбогдох нь

Энэхүү конвенцид дараах байдлаар тайлбар хийж хэрхэвч болохгүй.

- А. Биет бус соёлын өвийн аль нэг төрлийг өөртөө шууд багтаасан тийм Дэлхийн Өвийн үнэт зүйлийн, Соёлын ба байгалийн өвийг хадгалж хамгаалах тухай 1972оны Конвенцийн дагуу хамгаалагдах ёстой, статусыг өөрчлөх, хамгаалалтын түвшинг бууруулах;
- Б. Оюуны өмчийн эрх, мөн биологийн ба байгалийн нөөцийг ашиглахтай холбогдсон бөгөөд тухайн улсууд нэгдэн орсон Олон Улсын эрхзүйн актуудын дагуу оролцогч улсуудын хүлээсэн эрх үүргүүдийг хөндөх;

II. Конвенцийн байгууллагууд

4-р зүйл. Оролцогч улсуудын Ерөнхий Ассамблей

1. Оролцогч улсуудын Ерөнхий Ассамблей /цаашид “Ерөнхий Ассамблей” гэж нэрлэх/ нь энэхүү Конвенциор байгуулагдах бөгөөд Конвенцийн бүрэн эрхт байгууллага болно.
2. Ерөнхий Ассамблей нь хоёр жилд нэг удаа ээлжит чуулганаа хуралдуулна. Биет бус соёлын өвийг хамгаалах засгийн газар хоорондын Хорооны, эсвэл оролцогч улсуудын 1/3-ээс доошгүй хувийн шийдвэр юмуу хүсэлтээр ээлжит бус чуулганыг хуралдуулж болно.
3. Ерөнхий Ассамблей нь өөрийн үйл ажиллагааны дотоод журмыг батлана.

5-р зүйл. Биет бус соёлын өвийг хамгаалах Засгийн газар хоорондын Хороо

1. Цаашид “Хороо” гэж нэрлэгдэх биет бус соёлын өвийг хамгаалах Засгийн газар хоорондын Хороо нь энэхүү Конвенциор ЮНЕСКО-гийн дэргэд байгуулагдана. 34-р зүйлд заасны дагуу Конвенц хүчин төгөлдөр болмогц Ерөнхий Ассамблейд цугларсан оролцогч улсуудаас сонгосон 18 оролцогч улсын төлөөллөөс Хороог бүрдүүлнэ.
2. Хорооны гишүүн улсуудын тоог Конвенцид оролцогч улсуудын тоо 50-д хүрсэн тохиолдолд 24 хүртэл нэмэгдүүлж болно.

6-р зүйл. Хорооны гишүүн улсуудыг сонгох ба тэдгээрийн бүрэн эрхийн хугацаа

1. Хорооны гишүүн улсуудын сонгуулийг газарзүйн тэгш төлөөллийн болон ээлжлэн сольж сонгох шудрага зарчмаар явуулна.

2. Ерөнхий Ассамблейд чуулсан Конвенцид оролцогч улсууд Хорооны гишүүн улсуудыг жилийн хугацаагаар сонгоно.
3. Анхны сонгуулиар сонгогдсон Хорооны гишүүн улсуудын 50 хувийн бүрэн эрхийн хугацаа нь 2 жил байх бөгөөд эдгээр улсуудыг анхны сонгуулийн үед сугалаагаар шийдвэрлэнэ.
4. Хоёр жил тутам Ерөнхий Ассамблей нь Хорооны гишүүн улсуудын бүрэлдэхүүний 50 хувийг шинэчлэж байна.
5. Ерөнхий Ассамблей нь Хорооны гишүүн улсуудын тоог суудлын тоо бүрэн байхаар сонгоно.
6. Хорооны гишүүн улсын бүрэн эрхийн хугацааг 2 дараалан сонгохгүй.
7. Хорооны гишүүн улсууд нь биет бус соёлын өвийн янз бүрийн чиглэлээр мэргэшсэн хүмүүсийг өөрийн төлөөлөгчөөр сонгоно.

7-р зүйл. Хорооны гүйцэтгэх үүрэг

Энэхүү Конвенциор зөвшөөрөгдсөн бусад давуу эрхүүдэд хохирол үзүүлэхгүйгээр Хороо нь дараах үүргүүдийг хүлээнэ:

- А. Конвенцийн зорилгыг сурталчлах, түүний хэрэгжилтийг дэмжих, хяналт тавих;
- Б. Биет бус соёлын өвийг хадгалж хамгаалах арга хэмжээний тухай зөвлөмжүүд бэлтгэх, тэргүүний практикийг нэвтрүүлэх талаар удирдамж, заавраар хангах;
- В. 25-р зүйлийг үндэслэн сангийн хөрөнгийг зарцуулах тухай төлөвлөгөөний төслийг бэлтгэж, Ерөнхий Ассамблейд батлуулахаар оруулах;
- Г. Сангийн нөөцийг нэмэгдүүлэх арга замыг сүвэгчлэн олох, энэ зорилгоор 25-р зүйлд үндэслэн шаардлагатай арга хэмжээг авах;
- Д. Конвенцийг хэрэгжүүлэх талаарх Үйл ажиллагааны Удирдамж, чиглэл бэлтгэж, Ерөнхий Ассамблейд батлуулахаар оруулах;
- Е. 29-р зүйлийг үндэслэн оролцогч улсуудын тайлан илтгэлүүдийг хянан үзээд дүгнэлт гаргуулахаар Ерөнхий Ассамблейд оруулах;
- Ё. Оролцогч улсуудаас ирүүлсэн санал хүсэлтийг хүлээн авч танилцаад Хороогоор боловсруулагдаж, Ерөнхий Ассамблейгээр батлагдсан дараах сонгон шалгаруулах бодит шалгууруудыг үндэслэн шийдвэр гаргах; Үүнд:
 - I. 16,17,18–р зүйлүүдэд тусгагдсан жагсаалтууд болон саналуудад бүртгэж оруулах;
 - II. 22-р зүйлийг үндэслэн Олон Улсын дэмжлэг туслалцаа олгох.

8-р зүйл. Хорооны ажлын арга барил

1. Хороо нь Ерөнхий Ассамблейд ажлаа тайлагнах ба өөрийн бүхий л үйл ажиллагаа, шийдвэрүүдийн талаар илтгэнэ.
2. Хороо нь түүний гишүүдийн 2/3-оос дээш хувийн саналаар дотоод журмаа батална.
3. Хороо нь өмнөө тавьсан зорилтыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай гэж үзвэл зөвлөгөө өгөх тусгай байгууллагуудыг түр хугацаагаар байгуулж болно.
4. Хороо нь тодорхой асуудлаар зөвлөгөө авах зорилгоор хуралдаандаа төрийн болон хувийн байгууллагууд, тэрчлэн бодит бус соёлын өвийн янз бүрийн чиглэлээр мэргэшсэн нөлөө бүхий хувь хүмүүсийг урьж оролцуулж болно.

9-р зүйл. Зөвлөх байгууллагуудыг итгэмжлэн томилох

1. Хороо нь биет бус соёлын өвийн янз бүрийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудад тус Хороонд зөвлөх эрхтэйгээр ажиллах итгэмжлэл олгох тухай саналыг Ерөнхий Ассамблейд оруулна.
2. Хороо нь мөн итгэмжлэл олгох шалгуур, нөхцлүүдийн талаархи саналыг Ерөнхий Ассамблейд хэлэлцүүлэхээр оруулна.

10-р зүйл. Нарийн бичгийн дарга нарын газар

1. ЮНЕСКО-гийн нарийн бичгийн дарга нарын газар нь Хороонд дэмжлэг туслалцаа үзүүлнэ.
2. Нарийн бичгийн дарга нарын газар нь Ерөнхий Ассамблейд болон Хорооны баримт бичиг, тэдгээрийн хуралдааны хэлэлцэх асуудлын төслийг боловсруулан бэлтгэж, гарсан шийдвэрийн биелэлтийг хангана.

III. Биет бус соёлын өвийг үндэсний хэмжээнд хамгаалах нь

11-р зүйл. Оролцогч улсуудын үүрэг

Оролцогч улс бүр нь:

- А. Өөрийн нутаг дэвсгэр дээрхи бодит бус соёлын өвийг хамгаалахад чиглэгдсэн шаардлагатай арга хэмжээг авна.
- Б. 2-р зүйлийн 3-р хэсэгт заасан хамгаалалтын арга хэмжээний хүрээнд хүмүүсийн хамтын нийгэмлэг, бүлгүүд болон холбогдох төрийн бус байгууллагуудтай

хамтран өөрийн нутаг дэвсгэр дээрхи биет бус соёлын өвийн янз бүрийн элементүүдийг олж тогтоож тодорхойлно.

12-р зүйл. Бүртгэл хийх

1. Хадгалж хамгаалах үүднээс биет бус соёлын өвийг таньж тогтоох зорилгоор оролцогч улс бүр нь өөрийн нөхцөл байдалд тохирсон хэлбэр маягаар, нутаг дэвсгэртээ байгаа биет бус соёлын өвийн нэг буюу хэд хэдэн жагсаалтыг гаргаж болно. Эдгээр жагсаалтуудыг байнга шинэчлэж байх шаардлагатай.
2. 29-р зүйлд заасны дагуу тогтоосон хугацаанд оролцогч улс бүр нь өөрийн тайлан илтгэлээ Хороонд танилцуулахдаа эдгээр жагсаалтуудын талаар зохих мэдээллийг хийж байна.

13-р зүйл. Хамгаалалтын бусад арга хэмжээ

Өөрийн нутаг дэвсгэр дээрхи бодит бус соёлын өвийг хадгалж хамгаалах, хөгжүүлэх, хөхүүлэн дэмжих явдлыг хангах үүднээс оролцогч улс бүр нь дараах хүчин чармайлтыг гаргах ёстой:

- А. Нийгэмд биет бус соёлын өвийн үүрэг ролийг дээшлүүлэхэд чиглэгдсэн ерөнхий бодлого боловсруулан батлах ба энэ хэлбэрийн өвийн хамгаалалтыг төлөвлөж буй хөтөлбөрүүдэд тусгах;
- Б. Өөрийн нутаг дэвсгэр дээрхи биет бус соёлын өвийг хамгаалах зорилго бүхий нэг буюу хэд хэдэн мэргэжлийн байгууллагуудыг томилж, эсвэл байгуулж ажиллуулах;
- В. Биет бус соёлын өв, ялангуяа устах аюулд учраад байгаа биет бус соёлын өвийг үр дүнтэй хамгаалах үүднээс шинжлэх ухаан, техникийн болон урлагийн судалгаа, тэрчлэн судалгааны арга зүйг хөхүүлэн дэмжих;
- Г. Дараах чиглэлээр хууль эрхийн, техникийн, удирдлагын болон санхүүгийн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх. Үүнд:
 1. Биет бус соёлын өвийн удирдлага болон улмаар энэ төрлийн өвийг үзүүлж таниулах, илэрхийлэх зориулалттай хэлбэр, орон зайг хөгжүүлэх замаар өвлөн уламжлуулах асуудлаар ажиллах боловсон хүчин бэлтгэх байгууллагуудыг байгуулан бэхжүүлэх явдлыг хөхүүлэн дэмжих;
 2. Биет бус соёлын өвийн төрөл бүрийн хэлбэрийг үзэж танилцах явдлыг хангахын хамт ийм төрлийн өвийн өвөрмөц төрөл зүйлүүдийг үзэж эзэмшдэг уламжлалт зан заншлыг хүндэтгэн үзэх;

3. Биет бус соёлын өвийг баримтжуулах асуудал эрхэлсэн байгууллагуудыг байгуулж тэдгээрийг үзэж эзэмших явдлыг хөнгөвчлөх;

14-р зүйл. Боловсрол, олон нийтийн ойлголт ухамсрыг дээшлүүлэх болон чадавхийг бэхжүүлэх

Оролцогч улс бүр нь бүхий л тохиромжтой арга замыг хэрэглэн дараах чиглэлээр хүчин чармайлт гаргана. Үүнд:

А. Нийгэмд биет бус соёлын өвийг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, үүргийг нь дээшлүүлэх явдлыг, тухайлбал дараах арга хэрэгслэлээр зохион байгуулна.

Үүнд:

1. Бүх нийтийн, ялангуяа залуучуудад зориулсан боловсролын болон сурталчилгаа мэдээллийн хөтөлбөрүүдээр;
2. Хүмүүсийн тодорхой хамтын нийгэмлэг, бүлгүүдэд зориулсан боловсрол олгох, сургалт явуулах тусгай хөтөлбөрүүдээр;
3. Биет бус соёлын өвийг хадгалж хамгаалах, чадавхийг бэхжүүлэх, ялангуяа түүний удирдлагын менежмент болон шинжилгээ судалгааны асуудалтай холбогдсон үйл ажиллагаагаар;
4. Мэдлэгийг дамжуулан түгээх албан бус арга хэрэгслэлээр. Үүнд:

Б. Биет бус соёлын өвд учирч байгаа аюул занал, мөн энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх талаар авч явуулж байгаа үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлж байх замаар;

В. Биет бус соёлын өвийг илэрхийлж харуулахад зайлшгүй шаардлагатай байгалийн орчин, дурсгалт газруудыг хамгаалах асуудлаархи боловсролыг дэмжих замаар;

15-р зүйл. Хүмүүсийн хамтын нийгэмлэг, бүлэг, хувь хүмүүсийн оролцоо

Биет бус соёлын өвийг хамгаалах өөр өөрийн үйл ажиллагааны хүрээнд оролцогч улс бүр нь биет бус соёлын өвийг бүтээн бий болгох, хамгаалах, уламжлан дамжуулах үйлсэд хамтын нийгэмлэг, бүлгүүд шаардлагатай тохиолдолд хувь хүмүүсийн өргөн оролцоог бололцооныхоо хэрээр хангах, цаашилбал энэ төрлийн өвийн хамгаалалтыг удирдан зохицуулахад тэднийг татан оролцуулахыг эрмэлзэх;

IV. Биет бус соёлын өвийг олон улсын хэмжээнд хамгаалах нь

16-р зүйл. Хүн төрөлхтний биет бус соёлын өвийн Төлөөллийн Жагсаалт

1. Биет бус соёлын өвийг нийтэд түгээн дэлгэрүүлэх, түүний ач холбогдлыг гүнзгий ойлгуулан ухамсарлуулах, соёлын олон төрөл зүйлийг хүндэтгэж буй яриа хэлэлцээнүүдийг хөхүүлэн дэмжих асуудлыг хангах зорилгоор Хороо нь оролцогч улсуудын саналаар хүн төрөлхтний бодит бус соёлын өвийн Төлөөллийн Жагсаалтыг гаргах, шинэчлэн сайжруулах, хэвлүүлэх асуудлыг хариуцна.
2. Хороо нь энэхүү Жагсаалтыг гаргах, шинэчлэн сайжруулах, хэвлүүлэх шалгууруудыг боловсруулж Ерөнхий Ассамблейд батлуулахаар оруулна.

17-р зүйл. Хамгаалалтанд яаралтай авах шаардлагатай бодит бус соёлын өвийн Жагсаалт

1. Хороо нь хамгаалалтын холбогдох арга хэмжээг авах зорилгоор хамгаалалтанд яаралтай авах шаардлагатай биет бус соёлын өвийн Жагсаалтыг оролцогч улсуудаас ирүүлсэн саналыг үндэслэн гаргах, шинэчлэн сайжруулах, хэвлүүлэх асуудлыг хариуцна.
2. Хороо нь энэхүү Жагсаалтыг гаргах, шинэчлэн сайжруулах, хэвлүүлэх шалгууруудыг боловсруулж Ерөнхий Ассамблейд батлуулахаар оруулна.
3. Хороо нь онцгой тохиолдолд сонирхсон оролцогч улстай зөвшилдсөний үндсэн дээр, Хорооны саналаар Ерөнхий Ассамблейгээр хэлэлцэгдэн зөвшөөрөгдсөн бодит шалгууруудад тэнцсэн энэхүү хэлбэрийн өвийг энэ зүйлийн 1-р хэсэгт заасан Жагсаалтад оруулна.

18-р зүйл. Биет бус соёлын өвийг хамгаалах хөтөлбөр, төсөл, үйл ажиллагаанууд

1. Оролцогч улсуудын тавьсан санал хүсэлтийг үндэслэн Хороогоор тодорхойлогдож, Ерөнхий Ассамблейгээр батлагдсан шалгууруудаар Хороо нь хөгжиж буй орнуудын онцгой хэрэгцээ шаардлагад болон Конвенцийн зорилго, үйл ажиллагааны зарчимд бүрэн нийцсэн гэж үзэж буй тийм өвийг хамгаалах үндэсний болон бүс, дэд бүсийн хөтөлбөр, төсөл, арга хэмжээнүүдийг тодорхой хугацаанд сонгон шалгаруулах бөгөөд тэдгээрийг хэргэжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.
2. Энэ зорилгоор Хороо нь дээрхи санал хүсэлтийг бэлтгэхэд олон улсын тусламж авах талаар оролцогч улсуудын гаргасан өргөдлийг хүлээн авч хянан үзээд шийдвэр гаргана.

3. Хороо нь өөрийн зүйтэй гэж үзсэн арга хэлбэрийг ашиглан шилдэг тэргүүний практик үйл ажиллагааг дэлгэрүүлэх замаар дээрхи хөтөлбөр, төсөл, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг зохион байгуулна.

V. Олон Улсын хамтын ажиллагаа ба туслалцаа

19-р зүйл. Хамтын ажиллагаа

1. Энэхүү Конвенцийн зорилгод нийцсэн олон улсын хамтын ажиллагаа нь, тухайлбал: мэдээлэл, туршлага солилцох, хамтын санаачлага гаргах, тэрчлэн оролцогч улсуудаас биет бус соёлын өвийг хадгалж хамгаалахад чиглэгдсэн үйл ажиллагаанд нь тусламж үзүүлэх механизмыг бий болгох зэрэг асуудлыг хамарна.
2. Үндэсний хууль тогтоомж, эрхзүйн болон практик үйл ажиллагааны наад захын хэм хэмжээг зөрчихгүйгээр оролцогч улсууд нь, бодит бус соёлын өвийг хамгаалах нь нийт хүн төрөлхтний нийтлэг эрх ашиг мөн гэдгийг хүлээн зөвшөөрч, энэ зорилгоор 2 талын болон бүс, дэд бүс, цаашилбал олон улсын хэмжээнд хамтран ажиллах ёстой.

20-р зүйл. Олон Улсын тусламжийн зорилго

Олон Улсын тусламж нь дараахи зорилготой.

- A. Хамгаалалтад яаралтай авах шаардлагатай биет бус соёлын өвийн Жагсаалтад орсон өвийг хамгаалах;
- B. 11,12-р зүйлд заасны дагуу Жагсаалтуудыг бэлтгэн гаргах;
- V. Биет бус соёлын өвийг хадгалж хамгаалахад чиглэгдсэн үндэсний, бүс, дэд бүс нутгийн хэмжээнд хэрэгжиж байгаа хөтөлбөрүүд, төслүүд, арга хэмжээнүүдийг дэмжих;
- Г. Хорооноос зайлшгүй шаардалгатай гэж үзсэн аливаа зорилгыг хэрэгжүүлэх;

21-р зүйл. Олон Улсын тусламжийн хэлбэрүүд

Хорооноос оролцогч улсад үзүүлж байгаа тусламж нь 7-р зүйлд заасанчлан удирдамж, чиглэлүүд болон 24-р зүйлд заасан Гэрээгээр зохицуулагдах бөгөөд дараах хэлбэртэй байж болно. Үүнд:

- A. Хамгаалалтын янз бүрийн чиглэлээрх судалгаанууд;
- B. Биет бус соёлын өвийн шинжээчид болон практик ажилтнуудад дэмжлэг үзүүлэх;
- V. Шаардлагатай мэргэжлийн ажилтнуудыг сургаж бэлтгэх;

- Г. Хэм хэмжээ тогтоох болон бусад арга хэмжээг судлан боловсруулах
- Д. Дэд бүтцүүдийг байгуулах болон тэдгээрийг ажиллуулах;
- Е.Тоног төхөөрөмжөөр хангах болон шинэ арга барил нэвтрүүлэх;
- Ё.Тодорхой нөхцөлд бага хүүтэй зээл олгох, хандив оруулах зэрэг санхүү, техникийн тусламжийн бусад хэлбэрүүд ;

22-р зүйл. Олон Улсын тусламж олгох нөхцлүүд

1. Хороо нь олон улсын тусламж хүссэн өргөдлийг авч үзэх журам гаргаж, түүнд хэрэгжүүлэх арга хэмжээнүүд, зайлшгүй хийх шаардлагатай үйлдлүүд, тэдгээртэй холбогдсон зардлын үнэлгээ зэргийг тодотгон заана.
2. Яаралтай тохиолдолд тусламж хүссэн өргөдлийг Хороо тэргүүн зэрэгт авч үзэж хэлэлцэнэ.
3. Шийдвэр гаргах зорилгоор Хороо нь зайлшгүй шаардлагатай гэж үзсэн судалгаа хийх болон зөвлөлдөх арга хэмжээ авна.

23-р зүйл. Олон Улсын тусламж авахыг хүссэн өргөдөл

1. Оролцогч улс бүр өөрийн нутаг дэвсгэр дээрхи биет бус соёлын өвийг хамгаалахад олон улсын тусламж авах хүсэлтээ Хороонд ирүүлнэ.
2. Энэхүү хүсэлтийг 2 буюу түүнээс дээш улс хамтран гаргаж болно.
3. Хүсэлтээ 22-р зүйлийн 1-т заасан мэдээллийг, шаардлагатай бичиг баримтын хамт ирүүлнэ.

24-р зүйл. Тусламж авч буй оролцогч улсуудын үүрэг

1. Энэхүү Конвенцид зааснаар, олон улсын өгч буй тусламж нь тусламж авч буй оролцогч улс болон Хороо хоёрын хооронд байгуулсан Гэрээгээр зохицуулагдана.
2. Ерөнхий тогтсон журам ёсоор тусламж авч буй оролцогч улс нь өөрийн хөрөнгийн хэмжээнээс хамаарч, олон улсын тусламжаар хэрэгжиж буй хамгаалалтын арга хэмжээтэй холбогдон гарах зардлыг хуваалцана.
3. Тусламж авсан оролцогч улс нь биет бус соёлын өвийг хамгаалахад авсан тусламжийг хэрхэн ашигласан тухай тайланг Хороонд тавина.

VI. Биет бус соёлын өвийн Сан

25-р зүйл. Сангийн мөн чанар ба эх үүсвэр

1. Цаашид “Сан” гэж нэрлэгдэх биет бус соёлын өвийн Сан нь энэхүү Конвенциор байгуулагдана.
2. Энэхүү Сан нь ЮНЕСКО-гийн Санхүүгийн тухай дүрэмд заасан ёсоор тусгай зориулалтын Сан юм.

Сангийн эх үүсвэр нь дараах зүйлээс бүрдэнэ:

- A. Оролцогч улсуудын татвар;
 - B. Энэ зорилгоор ЮНЕСКО-гийн Ерөнхий Бага Хурлаар батлагдсан төсвийн хөрөнгө;
 - B. Дараах шугамаар оруулсан хандив болон бэлэг, гэрээслэн үлдээсэн эд хөрөнгө;
1. Бусад улсуудаас
 2. НҮБ-ын системийн байгууллагууд болон хөтөлбөрүүдээс, тухайлбал; НҮБ-н хөгжлийн хөтөлбөр, тэрчлэн олон улсын бусад байгууллагуудын хөтөлбөрүүдээс;
 3. Төрийн ба хувийн байгууллагууд, хувь хүмүүсээс;
- Г. Сангийн эх үүсвэрт олгосон аливаа хүү;
 - Д. Сангийн сан хөрөнгийг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулсан арга хэмжээнээс оруулсан ба цуглуулсан хөрөнгө;
 - Е. Хорооноос боловсруулсан Сангийн тухай журмуудад заасан хөрөнгийн бусад эх үүсвэрүүд;
4. Хороо нь сангийн хөрөнгийг зарцуулах тухай шийдвэрийг Ерөнхий Ассамблейн удирдамж, зааврыг үндэслэн гаргана.
 5. Хороо нь түүний дэмжин баталсан тусгай төслүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой ерөнхий болон тусгай зорилтуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн хандив болон бусад хэлбэрийн тусламжийг хүлээн авна.
 6. Санд хандив өгөх нь энэхүү Конвенцийн зорилго, үйл ажиллагаанд үл нийцэх улс төр, эдийн засгийн болон бусад ямар ч нөхцлийг дагалдуулах ёсгүй.

26-р зүйл. Оролцогч улсуудаас Санд оруулах хандив

1. Сайн дураар орж байгаа төрөл бүрийн нэмэлт хандивуудад хохирол үзүүлэхгүйгээр, оролцогч улсууд нь 2 жилд наад зах нь 1 удаа Санд хандив оруулах ёстой бөгөөд энэ хандивийн хэмжээг бүх улсад нийтлэг хэрэглэх хувь тэнцүү ноогдуулах зарчмаар Ерөнхий Ассамблей тогтооно. Энэ асуудлаарх Ерөнхий Ассамблейн шийдвэр нь энэхүү зүйлийн 2-т заасанчлан мэдэгдэл гаргаагүй бөгөөд оролцогч улсуудын санал хураалтад хүрэлцэн ирж, саналаа өгсөн улсуудын олонхийн саналаар батлагдана.

- Ингэхдээ тогтоосон хандивийн хэмжээ нь оролцогч улсуудын ЮНЕСКО-гийн ердийн төсөвт оруулдаг нийт хандивын нэг хувиас хэтэрч хэрхэвч болохгүй.
2. Гэхдээ энэхүү Конвенцийн 32,33-р зүйлд тодорхойлсноор улс бүр нь соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, батламжилсан буюу нэгдэн орсон тухай батламж бичгээ хадгалуулах үед энэхүү зүйлийн 1-дүгээр заалтыг хүлээн авах боломжгүй гэдгээ мэдэгдэж болно.
 3. Энэхүү зүйлийн 2-дугаарт заасны дагуу мэдэгдэл өгсөн бөгөөд Конвенцид оролцогч улс нь ЮНЕСКО-гийн Ерөнхий Захиралд мэдэгдсэний дараа мэдэгдлээ татан авч болно. Гэхдээ мэдэгдлээ татан авах нь тэр улс өгөх ёстой албан ёсны хандивыг оруулсан байдлаас шалтгаалж, Ерөнхий Ассамблейн дараагийн чуулган нээгдэх тэр өдрөөс өмнө хүчин төгөлдөр болохгүй.
 4. Хороо өөрийн үйл ажиллагааг үр дүнтэй төлөвлөсөн байхын тулд энэхүү зүйлийн 2-т заасан ёсоор мэдэгдлээ өгсөн бөгөөд Конвенцид оролцогч улсууд хандиваа цаад зах нь 2 жил тутамд тогтмол оруулж байх ба энэхүү зүйлийн 1 дүгээрт заасан заалтыг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд оруулах ёстой хандивын хэмжээнд аль болохоор ойртсон байх ёстой.
 5. Конвенцид оролцогч аливаа улс нь тухайн жил буюу урьдах хуанлийн жилд албан ёсны татвар болон сайн дурын хандиваа өгөөгүй бол Хорооны гишүүнээр сонгогдохгүй бөгөөд энэ заалт нь анхны сонгуульд хамаарахгүй. Хорооны ийм гишүүн улсын бүрэн эрхийн хугацаа нь энэхүү Конвенцийн 6-р зүйлд заасны дагуу явуулах сонгуулиар дуусгавар болно.

27-р зүйл. Сангийн сайн дурын нэмэлт хандивууд

26-р зүйлд зааснаас гадуур нэмэлт байдлаар сайн дурын хандив оруулахыг хүссэн оролцогч улсууд нь тус Хороо өөрийн үйл ажиллагаагаа үүнтэй зохицуулан төлөвлөсөн байх үүднээс энэ тухайгаа Хороонд аль болох түргэн хугацаанд мэдэгдэнэ.

28-р зүйл. Хөрөнгө хуримтлуулах олон улсын Аян

Оролцогч улсууд нь ЮНЕСКО-гийн ивээл дор Санд хөрөнгө цуглуулах зорилгоор зохион байгуулагдах олон улсын Аяныг боломжийн хэрээр дэмжинэ.

VII. Тайлан

29-р зүйл. Оролцогч улсуудын тайлан

Оролцогч улсууд нь Конвенцийг биелүүлэх зорилгоор батлан гаргасан хууль эрх зүй, зохицуулалтын болон бусад арга хэмжээний талаарх тайлангаа Хорооны шийдвэрт заасан хугацаа болон хэлбэрийн дагуу Хороонд ирүүлнэ.

30-р зүйл. Хорооны тайлан

1. Хороо нь өөрийн үйл ажиллагаа болон мөн 29-р зүйлд зааснаар оролцогч улсуудын тайлангуудыг үндэслэн Ерөнхий Ассамблейн чуулган бүрт тайлангаа тавина.
2. Энэхүү тайланг ЮНЕСКО-гийн Ерөнхий Бага хуралд танилцуулна.

VIII. Шилжилтийн нөхцөл

31-р зүйл. Аман болон биет бус соёлын шилдэг өвийн дээжист Тунхаглан зарласантай холбоотой асуудал

1. Хороо нь энэхүү Конвенцийг хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд хүн төрөлхтний аман болон биет бус соёлын шилдэг өвийн дээжист Тунхаглан зарлагдсан бүтээлүүдийг хүн төрөлхтөний биет бус соёлын өвийн Төлөөллийн Жагсаалтад шууд бүртгэж авна.
2. Хүн төрөлхтөний биет бус соёлын шилдэг өвийн Жагсаалтад эдгээр шилдэг дээжсийг бүртгэх нь 16-р зүйлийн 2 дугаарт заасны дагуу цаашид Жагсаалтад оруулахад хэрэглэхээр тогтоогдож буй шалгууруудыг урьдчилан шийднэ гэсэн хэрэг биш болно.
3. Энэхүү Конвенц хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлснээс хойш цаашид Тунхаглан зарлах талаар ямар нэг үйл ажиллагаа хийхгүй болно.

IX. Эцсийн шат

32-р зүйл. Соёрхон батлах, батламжлах ба батлах

1. Энэхүү Конвенцийг ЮНЕСКО-гийн гишүүн улсууд Үндсэн хуулийнхаа холбогдох заалтуудыг үндэслэн соёрхон батлах, батламжлах юмуу батлана.

2. Соёрхон баталсан, батламжилсан юмуу баталсан тухай баримт бичгүүдийг ЮНЕСКО-гийн Ерөний Захиралд хадгалуулахаар өгнө.

33-р зүйл. Нэгдэн орох

1. ЮНЕСКО-гийн Ерөнхий Бага Хурлаас түүний гишүүн бус боловч энэхүү Конвенцид нэгдэн орох урилга хүлээн авсан, аль ч улстүүнд нэгдэн орж болно.
2. Энэхүү Конвенцид НҮБ-ийн Ерөнхий Ассамблейн 1514 /ХҮ/ шийдвэр ёсоор бүрэн тусгаар тогтнолоо олж чадаагүй байгаа ч НҮБ-ын хүлээн зөвшөөрснөөр өөрийгөө бүрэн удирдах дотоодын засаглал бүхий бөгөөд энэхүү Конвенциор зохицуулагддаг аливаа асуудал, тухайлбал, тус Конвенциор зохицуулагддаг асуудлаар Гэрээ хийх зэрэг ажил хэргийг шийдэх бүрэн эрх бүхий нутаг дэвсгэрүүд нэгдэн орж болно.
3. Нэгдэн орох тухай батламж бичгийг ЮНЕСКО-гийн Ерөнхий Захиралд хадгалуулахаар өгнө.

34-р зүйл. Хүчин төгөлдөр болох

Энэхүү Конвенцийг соёрхон баталсан, батламжилсан, баталсан болон нэгдэн орсон тухай батламж бичгээ заасан хугацаанд буюу түүнээс өмнө хадгалуулахаар өгсөн аль ч улсын хувьд соёрхон баталсан, батламжилсан, баталсан буюу элсэн орсон тухай 30 дахь батламж бичгийг хадгалуулахаар өгснөөс хойш 3 сарын дараа хүчин төгөлдөр болно. Конвенцид оролцогч бусад улсуудын хувьд соёрхон баталсан, батламжилсан, баталсан болон нэгдэн орсон тухай батламж бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш 3 сарын дараа хүчин төгөлдөр болно.

35-р зүйл. Холбооны юмуу нэгдмэл бус үндсэн хуулийн систем

Дараах заалтууд холбооны юмуу нэгдмэл бус үндсэн хуулийн тогтолцоотой оролцогч улсуудад хэрэглэгдэнэ. Үүнд:

- А. Холбооны юмуу төвийн хууль тогтоох засаглалын хууль эрх мэдлийн хүрээнд хэрэглэгдэх энэхүү Конвенцийн зарим заалтуудын хувьд холбооны юмуу төв засгийн үүрэг нь холбооны бус оролцогч улсуудын үүрэгтэй нэг адил байна.
- Б. Холбоонд бие даасан бүрэлдэхүүн болон ордог бөгөөд Холбооны Үндсэн хуулийн системийн дагуу хууль тогтоох үүрэг хүлээгээгүй тийм штат, муж, провинц болон кантоны хууль эрх мэдлийн хүрээнд хэрэглэгдэх энэхүү Конвенцийн зарим заалтуудын хувьд холбооны засгийн газар нь эдгээр штат, муж, провинц болон кантоны эрх бүхий удирдлагуудад дээрх заалтуудыг, тэдгээрийг батлах тухай зөвлөмжийн хамт мэдэгдэнэ.

36-р зүйл. Цуцлах

1. Оролцогч улс нь энэхүү Конвенцийг цуцалж болно.
2. Цуцлалтыг бичгээр үйлдэх ба энэ нь ЮНЕСКО-гийн Ерөнхий Захиралд хадгалагдана.
3. Цуцлалт нь цуцалсан тухай актыг хүлээн авснаас хойш 12 сарын дараа хүчин төгөлдөр болно.

Цуцлалт нь Конвенцоос албан ёсоор гарсан хугацаа хүртэл Конвенцийг цуцалж байгаа оролцогч орны хүлээсэн санхүүгийн үүрэгт ямар ч тохиолдолд нөлөөлөхгүй болно.

37-р зүйл. Хадгалагчийн үүрэг

Энэхүү Конвенцийг хадгалагчийн хувьд ЮНЕСКО-гийн Ерөнхий Захирал нь 32, 33-р зүйлүүдэд заасны дагуу энэхүү Конвенцийг соёрхон баталсан, батламжилсан, баталсан, нэгдэн орсон тухай бүх батламж бичгүүд болон баримт бичгүүдийг хадгаламжинд өгсөн талаар болон 36-р зүйлд зааснаар Конвенцийг цуцалсан актын тухай энэхүү байгууллагын гишүүн улсууд, мөн 33-р зүйлд заасан гишүүн бус улсууд болон НҮБ-д мэдээлнэ.

38-р зүйл. Нэмэлт өөрчлөлт

1. Оролцогч улс нь энэхүү Конвенцид оруулах нэмэлт өөрчлөлтийг ЮНЕСКО-гийн Ерөнхий Захиралд бичгээр санал болгоно. Ерөнхий захирал энэхүү саналыг оролцогч бүх улсад явуулна. Энэхүү саналыг явуулснаас хойш 6 сарын дотор оролцогч улсуудын 50-иас илүү хувь нь энэхүү саналыг дэмжсэн хариулт ирүүлбэл Ерөнхий Захирал түүнийг Ерөнхий Бага Хурлын дараагийн чуулганд оруулан хэлэлцүүлж зохих шийдвэрийг гаргуулна.
2. Нэмэлт өөрчлөлт нь санал хураахад оролцсон оролцогч улсуудын 2/3-оос дээш хувийн саналаар батлагдана.
3. Энэхүү Конвенцид оруулсан нэмэлт өөрчлөлтүүдийг нь батласны дараа соёрхон батлуулах, батламжлуулах, батлуулах юмуу түүнд нэгдэн орсныг нь баталгаажуулахаар оролцогч улсуудад хүргүүлнэ.
4. Конвенцид оруулсан заалтууд нь энэхүү зүйлийн 3 дугаарт заасан батламж бичгүүдийг оролцогч улсуудын 2/3-нь хадгалуулахаар өгснөөс хойш 3 сарын дараа хүчин төгөлдөр болно. Гэхдээ энэ нь зөвхөн эдгээр заалтуудыг соёрхон баталсан, батламжилсан, баталсан юмуу түүнд нэгдэн орсон оролцогч улсуудад хамаарна. Харин нэмэлт өөрчлөлтүүдийг цаашид соёрхон батлах, батламжлах, батлах юмуу түүнд нэгдэн орох оролцогч улс бүрийн хувьд энэхүү нэмэлт өөрчлөлтүүд нь оролцогч улсаас соёрхон баталсан, батламжилсан, баталсан юмуу нэгдэн орсон тухай баримт бичгээ хадгалуулахаар өгснөөс хойш 3 сарын дараа хүчин төгөлдөр болно.

5. 3, 4-р заалтуудаар тогтоосон журам нь Хорооны гишүүн улсуудын тооны талаар заасан 5-р зүйлийн нэмэлт өөрчлөлтүүдийн хувьд хэрэглэгдэхгүй болно.
6. Энэхүү зүйлийн 4 дүгээрт заасны дагуу нэмэлт өөрчлөлтүүд хүчин төгөлдөр болсны дараа Конвенцид оролцогч улс хэрэв өөр бодол санаатай байгаагаа мэдэгдээгүй бол түүнийг:
 - (а) Нэмэлт өөрчлөлтүүд ийсэн Конвенцид оролцогч улс,
 - (б) Эдгээр нэмэлт өөрчлөлтүүдэд нэгдээгүй аль ч оролцогч улсын хувьд нэмэлт өөрчлөлтүүд хийгээгүй Конвенцид оролцогч улс гэж үзнэ.

39-р зүйл. Конвенцийн эх бичиг

Энэхүү Конвенцийг Араб, Хятад, Англи, Франц, Орос, Испани хэлээр 6 эх хувь үйлдсэн бөгөөд эх хувиуд адил хүчинтэй болно.

40-р зүйл. Бүртгэл

НҮБ-ын Дүрмийн 102-р зүйлийн дагуу энэхүү Конвенц нь ЮНЕСКО-гийн Ерөнхий Захирлын хүсэлтээр НҮБ-ын нарийн бичгийн дарга нарын газарт бүртгэгдэнэ.

